МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр Дугаар А/221 Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 21.3.2, 21.4.3, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“М Си Эс кока кола” гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани (РД:2663503)-ийн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/294 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтаар Мөрөн сум 12 дугаар баг Сүмбэр-1, 102 тоотод байршилтай 6712011826 нэгж талбарын дугаартай 4000м^2 худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмшигчийн мэдээлэлд өөрчлөлт орж, гадаадын хөрөнгө оруулалттай компани болсон тул газар “эзэмших” эрхийн төрлийг “ашиглах” эрхийн төрлөөр өөрчилж 5 жилийг хугацаатайгаар ашиглуулсугай.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/294 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд “М Си Эс кока кола” гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани (РД:2663503)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010705